

# КРИПТО ҮНДЭСТЭН ХК

2024 оны 12 сарын 19 өдөр

№24/12

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

“Ард Венчурс” ХХК-ийн хувьцааг худалдах,  
Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1, 76.1.17, 76.1.18 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1, 92.2 дахь хэсэг, Крипто Үндэстэн ХК-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, ТУЗ-ийн 2024 оны 9 сарын 4-ний өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- “Крипто үндэстэн” ХК-ийн 100%-ийн охин компани “Ард Венчурс” ХХК-ийн гаргасан бүх хувьцаа болох нэг бүр нь 10,000 (арван мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 100 (нэг зуу) ширхэг хувьцааг 1,000,000 (нэг сая) төгрөгөөр худалдсугай.
- Компанийн тухай хуульд заасны дагуу энэ Тогтоолоор шийдвэрлэсэн асуудлаар сонирхлын зөрчилтэй ТУЗ-ийн гишүүд санал хураалтад оролцоогүй болохыг дурдсугай.
- Тогтоолд заасан нөхцөлөөр Хөвсгөл ХК-тай Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ, Хувьцааны эрх шилжүүлэх гэрээг тус тус байгуулах, тэдгээрт гарын үсэг зурах, хувьцааны төлбөрийн нөхцөл, хуваарийг тохирох эрхийг Гүйцэтгэх захирал (О.Мөнх-Оргил)-д олгосугай.
- Компани нь “Ард Венчурс” ХХК-ийн хувьцааг бүхэлд нь худалдсантай холбогдуулан санхүүгийн тайлан тооцоонд холбогдох бүртгэл хийж ажиллахыг нягтлан бодогч (Б.Тэлмүүн)-д даалгасугай.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, эрх бүхий байгууллагад холбогдох бүртгэл хийлгэхийг Гүйцэтгэх захирал (О.Мөнх-Оргил)-д олгосугай.



ДАРГА

Ч.ГАНХУЯГ